

ослын Өөд богино хугацаанд мэдээ мэдээллийг Өөн зөв дамжуулан мэргэжлийн ангийг цаг алдахгүй цуглуулах шаардлагатай байна.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө, төгөнд тусгагдсан Өөрийн Өөд авах арга хэмжээний талаар орон нутагт улиралын чанартай гэрээт пост ажилуулан сум дундын тамгын дарга нартай харилцан уялдаа холбоотой ажиллаж, тухайн албан хаагч нь 14 хоногийн хугацаанд ажиллахдаа сургалт, сурталчилгаа зохон байгуулан биет байдал дээр Өөр усны аюулаас урьдчилан сэргийлэх, гарч байгаа хохиролын хэмжээ зэргийг ард иргэдэд ухуулан таниулах ажил нь тодорхой хэмжээнд Өргөнгөө Өгсөн байна. Өөрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хэрээнд аймгийн засаг даргын захирамж, онцгой байдлын газраас гаргасан зөвлөмжийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан иргэд, ахуй нэгж байгууллагад төргөн хөргөх шаардлагатай байна.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
821 дүгээр дамжааны суралцагч,
дэд хурандаа М.Буянбаатар*

БОЛЗОШГӨЙ АЮУЛТ Ө ЗЭГДЭЛ, ОСЛЫН ӨӨД ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ АСУУДАЛ

Хураангуй. Энэхүү нийтлэлээрээ Улаанбаатар хотод Өөсч болзошгүй аюулт Өзэгдэл, ослын Өөийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах асуудлыг хөндөж тавихыг зорилоо.

Төлхөөр Өг. Болзошгүй аюулт Өзэгдэл, осол, шуурхай удирдлага, зохицуулалт.

Монгол Улсад гамшгаас хамгаалах шинэ эрх зөийн орчин, шинэ тогтолцоо бий болоод удаагүй ч гамшигтай тэмцэх талаар олон талт Өйл ажиллагаа амжилттай явагдсаар ирлээ.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын Өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжлийг даган хотжилт, Өйлдвэрлэл, Өйлчилгээ Өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангах хэрээнд Өргөжин тэлж, хөд амын хэт их төвлөрөл, ажилгүйдэл, Өрхийн орлогоос хамааралтай ядуурал бий болж, Өөний улмаас аюулт Өзэгдэл, ослын тоо, давтамж жил ирэх тусам нэмэгдэж байршил, байр зөийн хувьд нийслэл хот маань ачааллаа даахаа больжээ. Улаанбаатар хотын оршин суугчдын Өндсэн хуулиар олгогдсон эрх, аюулгүй ажиллаж, амьдрах баталгааг хангах, тэдгээрт төрийн ажил, Өйлчилгээг хөртөөмжтэй, шуурхай хөргөж ажиллах чиг Өөрөгтэй онцгой байдлын байгууллагын нийслэлийн Аврах анги, Гал унтраах, аврах ангиуд шуурхай дуудлагаар ажиллах Өөд тээврийн хэрэгслийн зорчих хэсэг, гарц,

гэр хорооллын хаягжилт тодорхойгүй, зарим хэсэгт даваа гүйцээхгүй, шавар намаг ихтэй, халтиргаа гулгаатай байгаа нь аврах ажиллагааны техник хэрэгсэл хэрэглэн очиход цаг хугацаа алдах, хэт ихдээр барилгажилт, байр зүйн нам дор байршлаас тусгай зориулалтын автомашины богино долгионы холбооны хэрэгслийн сүлжээ сарних зэрэг асуудал нь дээрх хүчин зүйлээс хамаарч байна.

Зөвхөн нийслэл хотод 2015 онд өссөн нийслэл байдлын тоон үзүүлэлтээс авч үзэхэд нийт 3840 дуудлага бүртгэгдэж, үүнээс аврах ажиллагааны 460, объектын гал тиймрийн 3353, ой хээрийн тиймрийн 27 дуудлага¹-аар нийслэлийн Онцгой байдлын газрын Гал унтраах, аврах ангийн хүч хэрэгсэл ажилласнаас үзэхэд мөн тухайн илтгэлд дурдагдаж байгаа үндэслэл нотолж байна.

Дээрхи дүн мэдээ нь нийслэлийн оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт дуудлагын тоо 8.9%-иар, объектын гал тиймрийн тоо 8.7%-иар, аврах ажиллагааны тоо 6.2%-иар тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.

Энэ нь болзошгүй гамшгийн аюулын эрсдэлийг бий болгож, үүнээс улбаалж үлэмж их хэмжээний хохирол учрах, Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг сааруулж болзошгүй хүчин зүйл болоод байна. Иймд Улаанбаатар хотод болзошгүй аюулт үзэгдэл, ослын үеийн шуурхай удирдлага, зохицуулалтын зарим асуудлыг боловсронгуй болгох, энэ чиглэлд судалгаа хийх үндэслэл болж байгаа юм.

Тухайлбал нийслэл хотод нийслэлийн онд буюу 2015 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Баянзүрх дүүргийн Шар хаднаас зүүн хойшоо Гүнжийн ам, Шар хоолойн ам гэх газарт 3.5 болон 4.4 магнитудын хүчтэй хоёр удаагийн газар хүдлэлтийн аюул, Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Гранд повэр" ХХК-ийн нийслэлийн хийн үйлдвэрт гарсан ослын улмаас 11 иргэн хорт хийнд хордож, 3 хүн нас барсан химийн осол зэрэг нь өөсч болзошгүй гамшгийн аюулд хүн ам, мал амьтан, байгаль экологи, хүрээлэн буй орчин, эд хүрнэг бүртх магадлал ихдээр байгаа тул энэхүү учирч болох гамшгийн хохирлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах явдал нь эн тэргүүний зорилго юм.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд болзошгүй гамшгийн үед хариу арга хэмжээ явуулах түүхийн хохирлыг багасгах үүднээс шуурхай удирдлага, зохицуулалтын арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэх шаардлагатайг судлаач миний бие судалгааны ажлын хүрээнд тодорхой эх сурвалж болон судалгааны арга зүйд тулгуурлан хүндэтгэн болно.

¹ НОБГ-ын 2015 оны жилийн эцсийн статистикийн тоо, судалгаа

Гамшгийн Үеийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах асуудлын талаар авч Үзэхийн тулд юуны Үмн нэр томъёоноос эхлэх нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах ерөнхий удирдлага нь аюулт Үзэгдэл, осол сүйрлээс урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгохтой холбогдсон асуудлыг улс орны хэмжээнд гүйцэтгэнэ¹. Уг зохицуулалтаар гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээллийг хором бүр авч, ирүүлсэн мэдээлэл бүрт дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргаж, голомтонд ажиллаж байгаа бие бүрэлдэхүүнийг тогтвортой, тасралтгүй удирдлагаар хангаж ажилладаг. Зарим тодорхойлолтоос авч Үзэхэд “шуурхай удирдлага” гэж тив, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс ирсэн гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг хүлээн авч дүн шинжилгээ, нэлгээ хийж Үүссэн болон Үүсч болзошгүй нөхцөл байдалд гамшгаас хамгаалах арга хэмжээг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг² хэлнэ гэж тодорхойлжээ. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийн арилгах, гамшгийг хохирол багатай даван туулах, сэргээн босгох, хохирлын хэмжээг дээд зэргээр бууруулахад чиглэгдсэн цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх явдал нь гамшгийн Үеийн удирдлагын Үл тасалдах Үргэлжилсэн арга хэмжээ юм. Гамшиг ослын Үед эрэн хайх, аврах ажиллагааг амжилттай гүйцэтгэх нэг чухал Үндэс нь удирдлага, зохион байгуулалт мөн.

“Шуурхай ажиллагаа” гэж онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээг нэгтгэн цуглуулж, нэлгээ дүгнэлт хийх, удирдлагыг мэдээллээр тасралтгүй хангах, удирдлагаас гаргасан шийдвэрийг тухайн байгууллагад хүргэж, биелэлтийг зохион байгуулах цогц арга хэмжээ^{1 2 3}-г хэлнэ хэмээн заажээ.

Аюулт Үзэгдэл, ослын Үеийн шуурхай ажлын удирдлага нь төлөвлөгөө боловсруулах, Үүрэг даалгавараар хангах, төлний биелэх нөхцөлийг хангаж гүйх, хяналт тавих, боловсруулсан төлөвлөгөөнд засвар, Үүрчлөлт оруулах, идэвхижүүлэх Үйл явцыг хангаж ажиллана. Мөн ажиллагаанд оролцож байгаа хүн хүч, техникийн харилцан ажиллагааг

¹ О. Үржин. Эрэн хайх, аврах ажлын Үндэс. - УБ., 2012.

² Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн ажиллах журам - УБ., 2013.

³ Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам. - УБ., 2008.

зохион байгуулах, аюулгүйн нөхцөл байдлыг бүрдүүлж ажиллах шаардлагатай. Гамшгийн төвийн удирдлага нь нэгдмэл, нэг хариуцлагын тогтолцоотой байна. Гамшгийн удирдлагын эрхэм зорилго бол:

- Мэдээллийг баттай эх сурвалжаас үнэн зөв авах, шуурхай хураах, найдвартай мэдээ, мэдээлэлд тулгуурлан төвлөх ажиллагаагаа явуулахад холбоо, зарлан мэдээллийг ашиглах;

- Хүн амын эмзэг байдлаас өмнө болох гамшгийн болзошгүй хохирлыг бууруулах, боломжтой бол бүрмөсөн арилгах;

- Гамшигт нэрвэгдсэн хүн амд яаралтай туслэмж үзүүлэх;

- Урьд тохиолдож байсан эрсдэлээс бага эрсдэлтэй болгохын тулд үүрдхгүйн, урт хугацааны сэргээн босгох арга хэмжээг авахад оршино.

Гамшгийн төвийн удирдлагын төвлөх ажиллагаанд нөлөөлдөг зарим хүчин зүйлийг авч үзэх хэрэгтэй.

- Онцгой нөхцөл байдалд ажиллах дадлага, туршлагагүйгээс томилогдсон дарга өмнөхгүйн, удирдах чадваргүй болох;

- Удирдлагаас доод тушаалын чухал мэргэжлийн хүмүүст заавар үзүүлэхгүйн, тэдэнд яаралтай туслэмж явуулах нөхцөлийг хангах, холбооны хэрэгсэл эвдэрч гэмтэх, ажиллагаагүй болох;

- Аврах ажиллагаа явуулах мэргэжилтэн, багаж хэрэгсэл, машин техник зэрэг нөөц хүч хэрэгсэл хохирох гэх мэт олон зүйлийг дурдааж болохоор байна.

Тухайн онцлог, нөхцөл байдлаас хамааран гамшгийн төв удирдлагад нөлөөлж болох олон хүчин зүйл байх нь мэдээж юм. Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ нь гамшигт нэрвэгдэгсдэд болон төвлөх тэмцэх ажлыг удирдах ажилтны аль алинд нь маш их шаардлага тавихуйц нөхцөл байдал өмнөхдөг.

Ийм учраас энэхүү арга хэмжээг зохион байгуулж явуулахын тулд асуудлыг шуурхай, ухаалаг, оновчтой шийдвэр гаргах чадвар эзэмших зайлшгүй шаардлагатай.

Гамшиг осол, аюулт үзэгдлийн голомтонд юуны өмнө Онцгой байдлын алба, цэрэг, цагдаа, хүчний болон төрийн захиргааны байгууллагууд хүний амь нас, эд хөрөнгө, нэт зүйлсийг аврахаар ажилладаг билээ. Иймд гамшгийн төвийн шуурхай удирдлага, зохицуулалтын асуудлыг нарийвчлан судалж, хамтын ажиллагааны оновчтой загварыг бий болгох асуудал эн тэргүүнд тулгамдаж байна гэж судлаачийн хувьд үзэж байна.